



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/289

Улаанбаатар хот

Эх баригчийн албан тушаалын
үлгэрчилсэн тодорхойлолтыг шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эх баригчийн албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолтыг эрүүл мэндийн байгууллагын чиг үүрэгт нийцүүлэн боловсруулж батлан, мөрдүүлэхийг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (Л.Гэрэлмаа)-т даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн "Эх баригчийн албан тушаалын тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай" А/216 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С. ЧИНЗОРИГ

141241248

Эрүүл мэндийн сайдын 2024 оны...
дугаар сарын... өдрийн... дугаар
тушаалын хавсралт

ЭХ БАРИГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ҮЛГЭРЧИЛСЭН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2024 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2024 оны...дугаар сарын ...-ны өдөр

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд, эх барихуйн чиглэлээр эх, ураг, нярай ба эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй үзүүлнэ.

Албан тушаалын зорилт:

- Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- Амь тэнссэн, яаралтай тусламж шаардагдсан осол гэмтэл, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, шинэ болон сэргэн тархаж байгаа халдварын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- Мэдлэг, мэргэшил, ур чадвараа тогтмол дээшлүүлэх, судалгааны ажил хийх, мэргэжлийн чиглэлээр эрүүл мэндийн ажилтнуудад сургалт явуулах, анхан шатны бүртгэл маягыг хөтлөх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх– Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1. Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг батлагдсан журам, заавар, стандартын дагуу үзүүлэх;	Журам, заавар, стандартын хэрэгжилтийн хувь	Г
	1.2. Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, бэлгийн замаар дамжих халдвар, жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийг сонгох, хэрэглэх талаар иргэдэд зөвлөгөө өгч, сургалт сурталчилгаа хийх;	Зөвлөгөө өгсөн, сурсан хүний тоо	Г
	1.3. Нөхөн үржихүйн насны иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, жирэмслэхээс өмнөх тусламж, үйлчилгээ үзүүлэх;	Зөвлөгөө өгсөн, тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо	Г
	1.4. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэл, мэдээллийн тайлан, жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл (ЖСАХ)-ийн хэрэглээний хувь, төрөл тус бүрээр тооцсон судалгаа гаргах;	Ажлын тайлан	Г
	1.5. Сургалтад сууж гэрчилгээ авсан эх баригч умайн хөндийд ерөндөг тавих;	Умайн хөндийд ерөндөг тавьсан ажилбарын тоо	Г
	1.6. Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-ыг илрүүлэх түргэвчилсэн сорил хийж, эерэг тохиолдолд эмчид илгээх, эмчийн зааврын дагуу эмчлэх;	Түргэвчилсэн сорил хийсэн тоо, эмчлүүлсэн өвчтөний тоо	Т, Г
	1.7. Хөх, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ хийж, зөвлөгөө өгөх;	Эрт илрүүлгийн хувь, зөвлөгөө өгсөн хүний тоо	Т, Г
	1.8. Өсвөр үе болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн үржихүйн ба бэлгийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээнд тохирсон зөвлөгөө өгч, ээлтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх;	Зөвлөгөө өгсөн, тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо	Т, Г
	1.9. Эрсдэлт зан үйл, дадлыг (донтолт) илрүүлэх, хүчирхийлэлд өртсөн иргэдэд сэтгэл заслын зөвлөгөө, мэдээлэл өгөх;	Зөвлөгөө өгсөн, тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо	Т, Г

	1.10. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх;	Зөвлөгөө өгсөн, тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо	Т,Г
	1.11. Нөхөн үржихүйн дараах насны эмэгтэйчүүд, үргүйдэлтэй гэр бүлд анхан шатны тусламж үзүүлж, чиглүүлэх зөвлөгөө өгч эмчид илгээх;	Зөвлөгөө өгсөн хүний тоо	Т, Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1. Эх барихын тусламж, үйлчилгээг жирэмсэн, төрөх, төрсний дараах үед эх, ураг, нярайд батлагдсан журам заавар, стандартын дагуу үзүүлэх;	Журам, заавар, стандартын хэрэгжилтийн хувь	Т, Г
	2.2. Үйлчлүүлэгчийн эрх, ашиг, сонголт, сэтгэл зүй, соёл, зан заншлыг хүндэтгэсэн, үйлчлүүлэгч, түүний хамтрагч, гэр бүлийн шийдвэр гаргалтыг дэмжсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх;	Ажлын тайлан	Т, Г
	2.3. Хэвийн явцтай жирэмсэн эмэгтэйг эрт хяналтад авч шинжилгээнд бүрэн хамруулан өндөр эрсдэлийг илрүүлж, илэрсэн тохиолдолд эмчид илгээж, эмчийн зөвлөгөөг дагаж мөрдүүлэх;	Ажлын тайлан, хяналтад авсан жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо	Т, Г, Х
	2.4. Хэвийн явцтай жирэмсэн эмэгтэйг хянах, ургийн өсөлт хөгжил, ургийн зүрхний үйл ажиллагааг (стетоскопоор, ургийн бичлэг) хянан өөрчлөлт илэрсэн тохиолдолд эмчид илгээх;	Ажлын тайлан	Г, Х
	2.5. Жирэмсэн эмэгтэй, түүний хамтрагч, гэр бүлийнхэнд нотолгоонд суурилсан мэдээлэл, зөвлөгөө өгөх;	Ажлын тайлан, зөвлөгөө, мэдээлэл өгсөн тоо	Г
	2.6. Хэвийн явцтай жирэмсэн эмэгтэйн төрөлтийг эмчтэй хамтран багаар удирдаж, төрөлтийн явцад партограммыг бүрэн хөтөлж хянах;	Ажлын тайлан	Т, Г, Ш
	2.7. Төрөлтийн явцад эх, урагт эмгэг өөрчлөлт илэрвэл анхан шатны яаралтай тусламжийг үзүүлж, эмчид нэн даруй яаралтай мэдээллэж багаар тусламж үзүүлэх;	Эх барихын яаралтай тусламж үзүүлсэн тоо	Т, Г
	2.8. Төрсний дараах эрт үед эхийг төрөх өрөөнд хянаж, төрсний дараах тасагт шилжүүлэх;	Ажлын тайлан, хянасан эхийн тоо	Г,Х
	2.9. Төрсөн нярайг үнэлж, нярайн эрт үеийн нэн шаардлагатай (НЭҮНШТ) тусламж үзүүлэх;	НЭҮНШТ үзүүлсэн тоо	Г

	2.10. Бүтэлттэй төрсөн нярайд сэхээн амьдруулах тусламжийг яаралтай үзүүлж, нярайн эмч эсвэл их эмчийг дуудан тусламжийг багаар үзүүлэх;	Нярайд сэхээн амьдруулалт үзүүлсэн тоо	Т, Г
	2.11. Төрсөн эхэд зөвлөгөө (ЖСАХ, хөхөөр хооллолт, эрүүл ахуй, халдвар хамгаалал, хооллолт, дасгал хөдөлгөөн, төрсний дараах сэтгэлзүй) өгөх;	Ажлын тайлан, зөвлөгөө өгсөн эхийн тоо	Г, Х
	2.12. Төрсөн эх, нярайг батлагдсан журам, заавар, стандартын дагуу гэрийн эргэлтээр үзэж, хянах.	Гэрийн эргэлтийн тоо	Г
3 дугаар зорилтын хүрээнд	3.1. Эх барихын яаралтай тусламж шаардсан хүндрэлийг (манас таталт, цус алдалт, үжил, дайрлага, ураг орчмын шингэний бөглөрөл) эрт илрүүлж, тусламж иртэл анхны тусламжийг шуурхай үзүүлж, багаар тусламж үзүүлэхэд оролцох;	Эх барихын яаралтай тусламж үзүүлсэн тоо, эхийн ноцтой хүндрэлийн тоо	Т, Г
	3.2. Амь тэнссэн, яаралтай, онцгой, тохиолдолд эмнэлгийн нэн шаардлагатай тусламжийг (гэнэтийн өвчин, осол гэмтлийн үед ухаан алдсан, таталттай, амьсгал боогдсон, хаагдсан, зүрхний үйл ажиллагаа зогсох аюул тулгарсан үед) үзүүлж, дараагийн тусламж үйлчилгээг шуурхай зохион байгуулах;	Амь тэнссэн, яаралтай, онцгой тохиолдолд тусламж үзүүлсэн тоо	Т, Г
	3.3. Халдварт өвчний цар тахал, гамшиг тохиолдсон үед нөхөн үржихүй, эсэн мэнд амаржихуйн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлж бэлэн байдлыг хангах;	Мэргэжлийн тусламж үзүүлсэн тохиолдлын тоо	Т, Г
	3.4. Гамшиг, онцгой байдлын үед бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай багцыг хэрэглэхэд дэмжлэг үзүүлж ажиллах;	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	Т, Г
	3.5. Гамшиг, осол, онцгой тохиолдолд шууд харьяалагдах болон дээд албан тушаалтны шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу хамтарч ажиллах;	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	Т, Г
	3.6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой, анхан шатны бүртгэл маягтыг бүрэн хөтлөх;	Анхан шатны маягт хөтлөлтийн тайлан	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1. Зэрэг, цолтой туршлагатай эх баригч нь шинэ эх баригчдыг шавилан сургах;	Шавилан сургасан эх баригчийн тоо	Г, Х

4.2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдах; эх нярайд үзүүлэх яаралтай тусламжийн сургалтад хамрагдсан байх;	Сургалтын хөтөлбөр, бүртгэл, гэрчилгээ	Г
4.3. Эрдэм, шинжилгээ судалгааны ажил хийх, онол, практикийн хуралд оролцох, хэвлэн нийтлүүлэх;	Илтгэл, өгүүлэл, хурлын тоо	Г, Х
4.4. Гадаад хэл, компьютерын хэрэглээний мэдлэгээ дээшлүүлж ажиллах;	Гэрчилгээ	Г
4.5. Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаанд манлайлан оролцох.	Нийгэмлэгийн гишүүнчлэл, Ажлын тайлан	Г, Х

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	- Диплом/бакалаврын зэрэгтэй	
Мэргэжил	- Эх баригч	
Мэргэшил	- Төгсөлтийн дараах эх баригчийн мэргэшүүлэх сургалтад суралцсан байх /давуу тал/	
Туршлага	- Туршлагын шаардлагыг эрүүл мэндийн бодлого, хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн байгууллага тогтооно.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - Албан хэрэгцээнд шаардагдах өгөдлийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, санал, зөвлөмж боловсруулах - Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Тулгамдсан асуудлыг хууль тогтоомж, журмын хүрээнд шийдвэрлэх - Ажлын үр дүн, үр нөлөөг урьдчилан харах, хяналт тавих - Мэргэжлийн зөвлөгөө өгөх - Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай, хариуцлагатай ажиллах - Хувь хүний нууц хадгалах
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - Өөрийн мэдлэг туршлага, ур чадвар, мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах - Багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх - Байгууллагын зорилго, үйл ажиллагаанд нийцүүлж, үр бүтээмжтэй ажиллах - Хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмжих - Төрийн албан хаагч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг чанд баримтлан харилцааны соёлыг эрхэмлэх
	Бусад	<ul style="list-style-type: none"> - Хувийн зохион байгуулалттай ажиллах - Англи хэлний зохих түвшний мэдлэгтэй байх - Жил тутам 3 ба түүнээс дээш багц цагийн сургалтад хамрагдах - Оффисын хэрэглээний программ дээр ажиллах - Дотоод сүлжээ, интернэтийн орчинд ажиллах

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект

1. Тухайн байгууллагын харьяалан ажиллах тасаг, нэгжээс бусад тасаг, нэгжүүд
2. Анагаах ухааны боловсрол олгох их сургуулиуд, Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхэлдэг байгууллагууд
3. Мэргэжлийн нийгэмлэг, холбоо
4. Олон Улсын байгууллагууд, тэдгээрийн төсөл, хөтөлбөрийн нэгж
5. Төрийн бус байгууллагууд
6. Иргэд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

Байгууллагын нэр:.....

.....
 (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр,
 өөрийн нэр)

Шийдвэрийн огноо:

Дугаар:

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

.....
 (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр